

ОНЦГОЙ БАЙДЛЫН БОЛОН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БАЙГУУЛЛАГЫН ГАМШГИЙН ҮЕИЙН ХАРИЛЦАН АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Х.Сумъяа

*Дотоод хэргийн их сургуулийн Ахисан шатны боловсролын сургуулийн
гамишг судлалын магистрант, дэслэгч*

Хураангуй: Гамшгаас үеийн харилцан ажиллагааны онолын үндэс дээр тулгуурлан Монгол Улсын Онцгой байдлын болон Зэвсэгт хүчний байгууллагын гамшгийн үеийн хамрилцан ажиллагааны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, түүнийг сайжруулах арга замыг тодорхойлоход оршино.

Түлхүүр үг: Гамшиг, гамшгаас хамгаалах, Иргэний хамгаалалт, Зэвсэгт хүчин

Оршил

Монгол орон байгалийн гамшгийн эрсдэл ихтэй, эмзэг бүс нутагт оршдогоос үзэхэд манай улсын нутаг дэвсгэрт бүхэлдээ болон хэсэгчилсэн байдлаар өнө эртнээс байгалийн гамшигт нэрвэгдсээр иржээ.

Дэлхийн уур амьсгалын дулааралт, хувиралт болон хүний хүчин зүйлийн хам нөлөөгөөр сүүлийн 40 гаруй жилийн дотор хүрээлэн байгаа орчинд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсаар байна.

Дэлхий нийтэд түгээмэл тохиолддог 20 гаруй аюулт үзэгдлээс манай оронд элсэн болон шороон шуурга, аянга, мөндөр, хүйтэн болон аадар бороо, үер, их цас, цасан шуурга, ой хээрийн түймэр, ган, хэт халалт, хүйтрэл зэрэг 10 гаруй үзэгдэл байгалийн бүсийн өвөрмөц онцлогоос шалтгаалан байнга тохиолддог юм.

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагааны улмаас томоохон хэмжээний цаг агаар, геологи, биологийн гаралтай аюул ослын төрөл, тоо, давтамж жилээс жилд өсөн нэмэгдэж улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил, хүн амын амьжиргаанд сөрөг нөлөө үзүүлж байна. Цаг агаар, геологи, биологийн гаралтай аюул осол (цацраг, хими, биологи, тэсэрч дэлбэрэх бодис, үер, газар хөдлөлт) нь гэнэт, хурдан хугацаанд болж ихээхэн хэмжээний хохирол учруулж байна.

Гамшгийг хамгийн бага хохиролтойгоор даван туулах, хохирлыг бууруулахад дан ганц гамшгаас хамгаалах салбарт үйл ажиллагаа явуулдаг

төрийн байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлэх боломжгүй гэдгийг дэлхий нийт хүлээн зөвшөөрч үүнийг бүх талын оролцоо /улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах алба/, түншлэлийн замаар хэрэгжүүлэхийг чухалчлах болсон.

Энэхүү гэнэтийн гамшиг, ослын үед хариу арга хэмжээ авах, хор уршгийг арилгахад Зэвсэгт хүчний байгууллагын удирдлага зохион байгуулалт, бэлэн байдал, харилцан ажиллагааг хангах шаардлага зайлшгүй тулгарч байна.

Иймээс 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр шинэчлэгдэн батлагдсан “Гамшгаас хамгаалах тухай хууль”-ийн 33 дугаар зүйлд “Гамшгаас хамгаалах албаны чиг үүрэг”-ийг тодорхой тусгаж өгсөн бөгөөд гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг уялдуулан зохицуулах зорилгоор төрийн захиргааны байгууллагыг түшиглэн ажиллахаар хуульчилсан боловч гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн албад хоорондын харилцан ажиллагаа тодорхой бус байгаа тэр дундаа Зэвсэгт хүчний байгууллагын харилцан ажиллагааны талаар байхгүй байгаа учраас энэхүү судалгааны ажлаар гамшгийн үед хоёр байгууллагын харилцан ажиллагаанд хамаарч байгаа эрх зүйн баримт бичгүүдийн агуулгад шинжилгээ хийж, түүнийг хэрэгжүүлэх ямар боломж байгаа талаар санал дэвшүүлэхээр бэлтгэв.

Үндсэн хэсэг: Нэг. Онцгой байдлын болон Зэвсэгт хүчний байгууллагын харилцан ажиллагааны эрх зүйн үндсийн шинжилгээ

Манай оронд сүүлийн 13 жилд ой хээрийн түймэр 2381, үер 285, газар хөдлөлт 353, мал, амьтны гоц халдварт өвчин 1320, усны осол 1141 удаа тус тус тохиолдсон бөгөөд гамшиг, аюулт үзэгдэл ослын төрөл, тоо, хэмжээ өсч байгаа бөгөөд Онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг /эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох/ дангаараа гүйцэтгэх боломжгүй тул төрийн байгууллагуудын харилцан ажиллагааг сайжруулах шаардлага бий болж байна.

Эрх зүйн шинжилгээг Монгол Улсын үндсэн хуулийн заалттай нийцүүлэн боловсруулагдсан бодлогын баримт бичиг, түүнийг хэрэгжүүлэхэд хууль болон бусад дүрэм, журам гэсэн гурван чиглэлээр хийв.

1. Бодлогын баримт бичигт Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

Бодлогын баримт бичигт Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс, Монгол Улсын гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого зэргийг авч үзлээ.

а. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал.

“Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д³⁶ хоёр байгууллагын харилцан ажиллагааны холбогдолтой шууд заалт байхгүй боловч бодлого, стратегийн чанартай дараах заалтуудыг харилцан ажиллагаанд эрх зүйн үндэс болгох боломжтой байна. Үүнд: 3.1.2.1-т Нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зарчимтай уялдуулан Монгол Улсын газрын сангийн нэгдсэн бодлого, удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоно; 3.1.2.2-т Орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах, зэвсэгт хүчний нэгдмэл тогтолцоог төлөвшүүлж, зэвсэгт хүчнийг мэргэжлийн чиг баримжаатай, чадварлаг болгон хөгжүүлнэ. Улсын хилийн хамгаалалтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, урамшуулах бодлого явуулна; 3.1.2.3-т Гаднын дүрвэгсэд олноор хил даван орж ирэх, гэнэтийн хяналтгүй нөхцөл байдал үүсэхээс сэргийлэх бэлэн байдлын тогтолцоог бүрдүүлж, эрх зүй, улс төр, дипломатын цогц арга хэмжээ авна; 3.1.4.8-т Уламжлалт Бурхны шашин, соёлыг сэргээн хөгжүүлж, сүм хийдийн үйл ажиллагааг нийгмийн оюун санааг гэгээрүүлэх, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, ядуурлыг бууруулах, зовлон гамшигт нэрвэгдсэн хүн ардад туслалцаа үзүүлэх, байгаль орчныг хамгаалах үйлсэд чиглүүлэхэд төрөөс анхаарч, дэмжлэг үзүүлнэ. 3.5.2.1-т Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтөд дасан зохицох, сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх бодлого тодорхойлох, чадавхыг бүрдүүлэх, уг бодлогын хэрэгжилтийг зохицуулах үндэсний бүтцийг бий болгох, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд олон улсын санхүүгийн механизмыг өргөн ашиглах, бүх талын оролцоог хангах арга хэмжээ авна. 3.5.5.2-т Гамшгийн менежментийн тогтолцоог бэхжүүлж эмзэг байдлыг бууруулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулж, төв, орон нутгийн төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангаж ажиллах нөхцөлийг бүрдүүлж, чадавхыг бэхжүүлнэ. 4.1.8-т Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд иргэд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын идэвх, оролцоог урамшуулж, хамтын ажиллагааны тодорхой арга, хэлбэрийг бэхжүүлж, үр дүнг дээшлүүлнэ. 4.1.9-т Гамшиг, гэнэтийн аюул, халдлагатай тэмцэх үндэсний чадавхыг дээшлүүлж, эрсдэлийг бууруулна. Аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд болон

³⁶ Монгол Улсын их хурлын тогтоол УБ 2010, 48 дугаар тогтоол

төрийн бусад байгууллага онцгой нөхцөл байдал үүссэн үед хамтран ажиллах бэлэн байдлын түвшинг шинэ шатанд гаргана; гэсэн заалтууд орж байна.

б. Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс.

“Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс”³⁷-ийн 2.2-т “Монгол Улсын батлан хамгаалах тогтолцооны үндэс нь төр, захиргааны байгууллагууд,

нийт иргэний оролцоонд тулгуурласан орон нутгийн хамгаалалт, мэргэжлийн цэрэг суурилсан зэвсэгт хүчин, нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгаа болно”; 2.3.3-т “Орон нутгийн хамгаалалтын удирдлагыг нутгийн захиргааны бүх шатны байгууллага, төрийн цэргийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ. Орон нутгийн хамгаалалтыг зохион байгуулах үндсэн нэгж нь Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб байна”; 2.3.3-т “Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчийн ба хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэн бүр хуульд заасан дайчилгааны даалгавраар хүлээсэн үүргээ биелүүлэх урьдчилсан бэлтгэлтэй байна”; 2.6-д “Хүн амыг гамшиг, гэнэтийн бусад аюул, үй олноор устгах зэвсгийн хөнөөлөөс хамгаалах нь батлан хамгаалах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд нэгдсэн төлөвлөлт, нэгдмэл тогтолцоотой байна”; 5.2-т Бүс нутгийг хөгжүүлэх, хүн амыг амьдрах нөхцөл, суурьшлын бүс, дэд бүтэц бий болгох, боловсрол, соёл, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах эдийн засаг, нийгмийн цогц бодлогыг хэрэгжүүлнэ; 7.1-т Монгол Улсын төрийн цэргийн байгуулал нь тайван цагт зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, Онцгой байдлын байгууллагаас бүрдэнэ. Дайны байдлын үед хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллага нь Зэвсэгт хүчний бүтцэд үүрэг гүйцэтгэнэ. 7.8-т Цэргийн мэргэжлийн дээд удирдлага гэж цэргийн нийтлэг дүрмийн хэрэгжилтийг хангах, Зэвсэгт хүчин, Хилийн ба дотоодын цэргийн, Онцгой байдлын байгууллагуудын харилцан ажиллагаа, байлдааны бэлэн байдлыг хангах, хамтарсан сургалт, бэлтгэлийн нэгдсэн төлөвлөлтийг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих, цэргийн байгууллагын зэвсэглэл, техникийн харилцан уялдааг хангах, холбоо мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн удирдлагын цогц үйл ажиллагааг ойлгоно. 7.9-т Цэргийн мэргэжлийн дээд удирдлагыг Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, хилийн ба дотоодын цэргийн командлагч, Онцгой байдлын байгууллагын дарга болон төрлийн цэргийн командлагч хамтран хэрэгжүүлэх бөгөөд түүний уялдаа холбоог

³⁷ Монгол Улсын их хурлын тогтоол УБ 2015, 85 дугаар тогтоол

хангах ажлыг Зэвсэгт хүчний жанжин штабын дарга хариуцна. 8.2-т Зэвсэгт хүчин тайван цагт ...8.2.4. Гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох олон улсын хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаанд туслах, үүрэг хүлээнэ.гэж тус тус заасан нь тогтолцоо, нэгдсэн төлөвлөлттэй болгох талаас нь тодотгож, харилцан ажиллах, удирдлагын талаар тодорхой тусгахаас гадна Зэвсэгт хүчний тайван цагийн гүйцэтгэх үүрэгт гамшгийн үед туслахаар оруулсан байна.

в. Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого.

“Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого³⁸”-ын үндсэн чиглэлийн 2.1-т Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоог бэхжүүлж, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төв орон нутгийн төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангана; 2.2-т “Байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн гаралтай гамшгийн төрөл тус бүрээр эрсдэлийн үнэлгээ хийж, гамшгийн эмзэг байдлыг бууруулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулна”; гэж тус тус заасан.

Мөн³⁹ “Гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн нийтлэг үндэслэлд **Цаг агаарын** дулаарлаас үүдэлтэйгээр манай оронд ган, зуд, цасан болон шороон шуурга, ой, хээрийн түймэр, цөлжилт, хэт халалт, хүйтрэл зэрэг байгалийн гамшгаас гадна хүн, мал, амьтны гоц халдварт өвчин, хортон шавж, үлийн цагаан оготны тархалт, үйлдвэр, тээврийн хэрэгсэл, уул уурхайн ашиглалтаас химийн хорт бодис, тэсэрч дэлбэрэх бодисын осол нэмэгдэж байна. Жилд дунджаар 2700 гаруй аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол тохиолдож, гамшгийн улмаас хүний амь нас эрсдэж, эд хөрөнгө, байгалийн ихээхэн хэмжээний хохирол учирч, эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлдөг. Гамшгийн нөлөөллөөс үүсэх хор уршгийг хохирол багатай даван туулах асуудал нь гамшгаас хамгаалах чадавхаас ихээхэн хамаарч байна.” гэж тусгажээ.

Энэ нь гамшгийн аюул, осол нь хил орчмын нутаг дэвсгэрт хамгийн их тохилддог хүн, мал, амьтны гоц халдварт өвчин, шороон болон цасан шуурга, ойн болон тал хээрийн түймрийн асуудал бөгөөд аюулт үзэгдлийн явц маш хурдан явагддаг хамрах хүрээ өргөн түүнээс үүсэх хохирол асар их гарсан даруйд нь хариу арга хэмжээг хурдан шуурхай авах шаардлагатай болдог.

2. Монгол Улсын хуулиуд.

³⁸ Монгол Улсын их хурлын тогтоол УБ 2011, 22 дугаар тогтоол

³⁹ “Гамшгаас хамгаалах талаарх бодлогын баримт бичгүүд” 2016, х 7,

Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай, Гамшгаас хамгаалах тухай, Монгол Улсын Батлан хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Монгол Улсын Цэргийн албаны тухай зэрэг бусад холбогдолтой хуулиудын хүрээнд онцгой байдлын үед гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах ажил зохион байгуулагдаж байна.

“Монгол Улсын Үндсэн хууль”-ийн 11 дүгээр зүйлийн 11.1-т Эх орныхоо тусгаар тогнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.⁴⁰;

“Үндэсний аюулгүй байдлын тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.1-т Нутгийн өөрөө удирдах байгууллага төрийн бодлого, хууль тогтоомжид нийцүүлэн нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлаар бодлого боловсруулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллана. 11 дүгээр зүйлийн 11.1-т Бүх шатны засаг дарга үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаанаас сэргийлэх, таслан зогсоох, түүний шалгаан нөхцлийг судлан тогтоох, арилгах арга хэмжээг авч, энэ асуудлаар нутаг дэвсгэртээ байгаа үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй албадад чиглэл өгч, холбогдох байгууллагад санал, хүсэлт тавина.⁴¹ гэж тус тус заасан.

Манай оронд элбэг тохиолддог гамшгийн үед хүчний байгууллагуудыг татан оролцуулах тухай Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.3-т гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төрийн цэргийн байгууллагын зарим анги, салбарыг оролцуулах шийдвэрийг зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн зөвшөөрснөөр гаргах;⁴²

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-т Хүн амыг гамшиг, гэнэтийн бусад аюул, аливаа хөнөөх хэрэгслийн хөнөөлөөс хамгаалах нь батлан хамгаалах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд нэгдсэн төлөвлөлт, нэгдмэл тогтолцоотой байна;⁴³

Онц байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан онцгой нөхцөл, түүний үр дагаврыг арилгах, нийгмийн амьдралыг хэвийн болгоход нутгийн захиргааны болон цагдаагийн байгууллагын хүч хэрэгсэл хүрэлцэхгүй байгаа тохиолдолд дор

⁴⁰ Монгол Улсын үндсэн хууль. УБ.,1992 он

⁴¹ Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. УБ.,2001 он

⁴² Гамшгаас хамгаалах тухай хууль. УБ.,2017 он

⁴³ Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль. УБ.,2016 он

дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд зэвсэгт хүчин, хилийн цэргийн зарим анги, байгууллагыг татан оролцуулж болно;⁴⁴

3. Дүрэм, журам.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 149 дүгээр зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт “Гамшгийн үед хүч хэрэгслийг дайчлан гаргах журам”, 2 дугаар хавсралт “гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам” болон бусад эрх зүйн баримт бичгүүдийн хүрээнд гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах ажил зохион байгуулагдаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн хавсралтад 2.3-т Хөтөлбөрийн хамрах хүрээ: Хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд бүх шатны төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, хуулийн этгээд, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, гамшгаас хамгаалах сайн дурынхан, хоршоо, нөхөрлөл, малчдын бүлэг, иргэд хамрагдана. 2.4-т Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ 2.4.3. төр, хувийн хэвшил, олон нийтийн түншлэл, хамтын ажиллагаанд тулгуурласан байх. 4.1-т Орон нутгийн хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх, тайлан, мэдээ гаргах ажлыг бүх шатны Засаг дарга, Онцгой байдлын асуудал хариуцсан нэгж, гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангийн удирдлага хариуцна.,

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны “Төлөвлөгөө батлах тухай” 416 дугаар тогтоолын Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал, амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө хавсралтад гамшгийн үед ажиллах байгууллагуудын харилцан ажиллагааны зохицуулалтаас харахад газар хөдлөлт, хүний гоц халдварт өвчин, ган, зуд, хүчтэй цасан болон шороон шуурга, үер, мал амьтны гоц халдварт өвчин, хортон шавьж, мэргэчид тархах, ой, хээрийн түймэр, химийн хорт болон аюултай бодис алдагдах, цацраг идэвхт бодис алдагдах, үйлдвэрлэлийн ослын төрлүүдэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах байгууллагаар батлан хамгаалах яам, хангалт, зохион байгуулалтын төлөвлөгөөнд холбоо, хүн эмнэлэг, орон байр, хувцас, хэрэгсэл, хоол хүнс, тээврийн хэрэгсэл, хүч хэрэгсэл, түлш эрчим хүчний хангалт, Олон Улсын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах үеийн тээвэрлэх, хуваарилах ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх байгууллагад Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, гамшгийн хор

⁴⁴ Онц байдлын тухай хууль. УБ.,1995 он


уршгийг арилгах, сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөөнд нэрвэгдэгсдийг ангилах, анхны болон нарийн мэргэжлийн тусламж үзүүлэх, улсын онц чухал болон хүн амын амьжиргааны хангамжийн объектыг хамгаалалтад авах, галын онц аюултай болон аюултай барилга байгууламжийг хамгаалалтад авах, нийтийн аюулгүй байдлыг хамгаалах ажиллагааг зохион байгуулах, гамшгийн голомтод холбоо зохион байгуулах, 24 цагийн жижүүрлэлтэд шилжүүлэх, нэрвэгдэгсдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлэг, цогцос хадгалах байрыг байгуулах, гамшгийн нөөцийг хуваарилах, ханагалтыг зохион байгуулах, Онцгой байдлын үед ажиллах тусгай дэглэм тогтоох, мөрдүүлэх, Зэвсэгт хүчин, хилийн цэргийн анги, салбарыг дайчлах, гамшгийн улмаас нас барагсдыг таниулах, цогцос цуглуулах, зөөвөрлөх, хадгалахад дэмжлэг үзүүлэх байгууллагаар Зэвсэгт хүчний жанжин штабыг оруулахаас гадна гамшгийн төрөл бүрээр хийгдэх ажлыг удирдан зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх байгууллагуудыг тусгасан нь хийх ажлуудыг тусгайлан өгсөн байна.

Мөн Зэвсэгт хүчний жанжин штабын анги, нэгтгэлүүд хамтын ажиллагааны төлөвлөгөө байгуулж, болзошгүй гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулан түүнийхээ дагуу хамтран ажиллаж байна.

Хоёр. Харилцан ажиллагааг сайжруулах боломж

Хамгийн нэгдүгээрт харилцан ажиллагааг сайжруулах боломжийг системийн хандлагын үүднээс Онцгой байдлын үед үндэсний аюулгүй байдлын тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын харилцан ажиллагааны зохион байгуулалтын дараах бүдүүвчээс харж болохоор байна.

Зураг 2 ҮАБХТЧҮББ-дын харилцан ажиллагааны бүтэц



- ✓ Гамшгаас хамгаалах тухай хуулинд Гамшгаас хамгаалах албадын бүрэлдэхүүнд оруулсны дараа үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүргийг тодорхой зааж өгөх;
- ✓ Байгалийн гамшиг, аюулт үзэгдлүүдийн үед мэргэжлийн дэмжлэг авах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, дүн шинжилгээ хийхийн тулд нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, хамтран туршлага солилцох;
- ✓ Цаашид хамтран ажиллах тулгамдаж байгаа асуудал, ирээдүйн чиг хандлагын тодорхойлох зорилгоор нээлттэй хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулж, санал солилцох;
- ✓ Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсүүдтэй Зэвсэгт хүчний анги, нэгтгэлүүд хамтын ажиллагааны гэрээ байгуулж болзошгүй гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг тодотгох;
- ✓ Гамшгаас хамгаалах чиглэлээр хамтарсан дадлага, сургалт зохион байгуулах, үр дүнг тооцох;

- Зэвсэгт хүчний байгууллага-Онцгой байдлын байгууллагын харилцан ажиллагааг шинэ шатанд гаргаснаар гамшгийн аюул, осол тохиолдох үед хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулах, эд хөрөнгөд халдах, эвдлэн сүйтгэх, болзошгүй үйлдлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах нөхцөл бүрдэнэ.
- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.2.4-т зааснаар аюулгүй байдалд хандах хандлага, түүнийг хангах үйл ажиллагаа нь мэдлэг, мэдээлэл, дүн шинжилгээнд суурилж, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь шинжлэх ухааны үндэслэлтэй байх заалтыг хэрэгжүүлэх, мөн бие бүрэлдэхүүнд цэгцтэй мэдлэгийг бий болгоно.

Дүгнэлт

Эрх зүйн шинжилгээнээс үзэхэд Зэвсэгт хүчний байгууллага болон Онцгой байдлын байгууллагын харилцан ажиллагаа, хоорондын хамаарал уялдааг тодорхойлсон байдал системчлэгдэж чадсан ч хамтран ажиллах гэрээ, төлөвлөгөө нууцийн гэх нэрийн доор тодорхой бус хэрэгжилт хангалтгүй байна;

Гамшгаас хамгаалах албадын бүрэлдэхүүнд оруулсны дараа үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүргийг тодорхой зааж өгөх;

Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, түүний бэлтгэл, бэлэн байдлыг хангаж, болзошгүй гамшгийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд учрах хохирлыг бууруулах асуудлыг Зэвсэгт хүчний байгууллага болон онцгой байдлын байгууллагууд хамтран судалж тохиолдож буй хүндрэлүүдийг хамтран шийдвэрлэх;

Харилцан ажиллагаатай анги, салбар, байгууллагуудын хүч хэрэгслийг гамшгаас хамгаалах ажиллагаанд татан оролцуулахдаа цагийн байдлын өрнөлт, отрядын бэлэн байдлын зэргүүдийг харгалзан тэдгээрийг хаана, юунд, хэдийд ашиглах, тэдний үүрэг, бэлэн болох хугацаа, харилцан ажиллах журмыг тодорхойлон урьдчилсан төлөвлөгөөнд тодотгол оруулна гэж заасныг бодит цагийн байдал дээр хэрэгжүүлж ажиллах арга ажиллагаа, туршлага хуримтлуулах шаардлагатай байна.

Ашигласан материал

Хууль тогтоомж, дүрэм

1. Гамшгаас хамгаалах талаарх бодлогын баримт бичгүүд УБ.2016 он
2. Гамшгаас хамгаалах тухай хууль УБ. 2017 он
3. Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль УБ. 2016 он
4. Монгол Улсын Үндсэн хууль. УБ. 1992 он
5. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал УБ. 2010 он

Ном зохиолууд

6. Адьяасүрэн.Ц., Цэрэндаваа.С. “Гамшиг, ослын үеийн удирдлага зохицуулалт” УБ. 1999 он
7. Баяраа.Н., Дамдин.П. “Монгол оронд тохиолддог аюулт үзэгдэл, гамшиг, сургамж” УБ. 2006 он
8. Д.Сэржмядаг “Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоо” УБ 2013 он
9. Дамдин.П., Цэдэв.П. “Гамшгийн эрсдлийг бууруулах менежмент” УБ. 2005 он
10. Дамдин.П, Жанчив.Б “Эргэн дурсах он жилүүд” УБ 2004 он
11. Мөнхнаран. С “Эх орон минь амгалан байг” УБ 2015 он
12. Монгол улсын иргэний хамгалалт / түүхийн тойм/ УБ 1999 он